



## СОНОМБАЛЖИРЫН БУЯННЭМЭХИЙН НЭГЭН ЖҮЖГИЙН ЗОХИОЛ ХЯТАДЫН “ХҮЙТЭН УУЛЫН БИЧИГ”-ТЭЙ ХОЛБОГДОХ НЬ

Боржигон Чулуу

Хятадын Төвийн үндэстний их сургуулийн докторант

**Abstract:** S.Buyannemeh is a important bridge between Mongolian and Chinese literature. This paper mainly compare the story of Hasar beat to death the tiger, the figure and the language in THE LITTLE HERO TEMUJIN which a drama written by S.Buyannemeh who the literary theorist and the founder of modern literary theory in Mongolia to ALL MEN ARE BROTHERS which a famous novel of Chinese. ALL MEN ARE BROTHERS is essence of Chinese literature. The Mongolian version of ALL MEN ARE BROTHERS flow into Mongolian is objective conditions for author to know Literary classics of Chinese. It is considered that THE LITTLE HERO TEMUJIN have imitated the writing techniques of ALL MEN ARE BROTHERS. For example, Likui and Wusong in ALL MEN ARE BROTHERS is Hasar and Bilguudai in THE LITTLE HERO TUMUJIN. Songjing in ALL MEN ARE BROTHERS is Chingis khan in this drama. The language and the writing techniques in this drama is different from his other works. tasted of Chinese literature from this drama, It's a unique types or forms in Mongolian literature. Finally, judging the possibility of the author how to influenced by the ALL MEN ARE BROTHERS.

**Түлхүүр үг:** “Баатар хөвгүүн Тэмүжин”, “Хүйтэн уулын бичиг”, харьцаа холбоо

Утга зохиолын онолч, монголын орчин үеийн уран зохиолын үндэслэгч Сономбалжирын Буяннэмэхийн зохиол бүтээлийн тухай Өвөрмонголын зарим нэг судлаачид 1980-аад оноос системтэйгээр судлах болсон нь XXI зууны эхэн үед хамаарна. Үүнд, профессор Ван Мандуга, профессор Эрхэмбаяр нарыг төлөөлүүлэн дурдаж болно. Сономбалжирын Буяннэмэхийн “Баатар хөвгүүн Тэмүжин” хэмээх жүжиг уран зохиол судлаачдын

хувьд төдий шинэ зүйл биш юм. XX зууны наяд онд профессор Хасчимэг “Бахдан үнэлүүштэй “Баатар хөвгүүн Тэмүжин” хэмээх өгүүлэлдээ уг жүжгийг “дотоод монголын жүжиг” (Хасчимэг, 2007, х.77) хэмээн ташаа үзэж байсан бөгөөд хожим нь энэхүү үзлээ залруулж “Хорьдугаар зууны монгол уран зохиолын судлал” хэмээх номдоо “... миний бие мөн олны аяыг дагаж түүнийг дотоодын зохиолоор үзээд тус өгүүллийг бичсэн байжээ” (Хасчимэг, 2007, х.5) гэж өөрийн үзэл бодлоо цагаатгасан юм. Бусад эрдэмтдийн судалгаанд ч С.Буяннэмэхийн намтар түүх буюу “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжгийн тухай эндүү үзэж байсан зүйл байгаа юм. Жүжиг судлаач Жагмийн “Зуу-Уд монгол жүжиг урлаг жич судалгаа” хэмээх номд “... Гэрэлт, Ёст, Чойжийн бичсэн “Архи” хэмээх жүжиг болон Ардын хувьсгалт намын төв хорооноос нийтэлсэн Цэцэнбилигтийн есөн үзэгдэлт “Баатар хөвгүүн Тэмүжин” хэмээх хоёр жүжиг болно. Энэхүү хоёр жүжиг нь Мао тэргүүлэгчийн “Янь Аны утга урлагийг ярилцах хурал дээр хэлсэн үг”-ийн суут гэгээн туяаралын доор тайзны жүжгийн хамгийн тэргүүний уран бүтээл болох юм” (Жагми, 2004, х.436) гэж мөнхүү С.Буяннэмэх (Цэцэнбилигт хэмээх нь С.Буяннэмэхийн нөгөө нэр) буюу түүний “Баатар хөвгүүн Тэмүжин” хэмээх жүжгийг дотоод монголын хэвчээнд, тэрчлэн Мао тэргүүлэгчийн загвартай холбогдуулан үзжээ.

Судалгааны талаарх эдгээр эндүүрэл нь ерөнхийдөө С.Буяннэмэхийн тухай судалгааны материал хомс байсан тухайн цаг үетэй холбогдолтой юм. Гэвч сүүлийн жилүүдэд С.Буяннэмэхийн зохиол бүтээлүүд удаа дараа хэвлэгдэн гарч олны хүртээл болж байгаа билээ. Энэ нь С.Буяннэмэхийн

тухай судалгааны ажлуудад сайн үр дагавар болсон ажээ. С.Буяннэмэхийн “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжиг бол найман үзэгдэлт жүжиг болно. Үүнд, “Есүхэйн мордсон нь”, “Бөртгөлжиний сүй тогтсон нь”, “Есүхэй бие барсан нь”, “Урвагсадыг эгүүлсэн нь”, “Чирлах өвгөнийг оршуулсан нь”, “Тэмүжин тайчуудад баригдсан нь”, “Тэмүжин тайчуудаас дутаасан нь”, “Сорхон шарын тусламж” зэрэг найман үзэгдлээс бүрэлджээ. Ерөнхий агуулгыг нь “Монголын нууц товчоо”-ны & 61- & 87-той үндсэндээ адил юм. Үүнд Есүхэй баатар Тэмүжинийг дагуулан Олхнууд аймгаас бэр гуйхаар очихоос эхлэн Тэмүжин Сорхон шарын тусламжаар амь гарсаныг өгүүлэн жүжиг төгсөнө. Жүжгийн үндсэн агуулга нь “Монголын нууц товчоо”-г мөрдөж бичсэн боловч бичлэгийн арга зэрэг бусад талаараа “Монголын нууц товчоо”-той огт адилгүй. Харин сонирхолтой нь уг жүжиг бичлэгийн арга, дүр бүтээлт, зарим агуулга, хэл хэллэг, дүрслэл зэрэг талаараа хятадын “Хүйтэн уулын бичиг” буюу “Шүй Хэүгийн үлгэр”-тэй ямар нэг хэмжээгээр холбогдох ажээ.

### **Нэг. Хасарын барс алсан үлгэрийн харьцуулал**

“Баатар хөвгүүн Тэмүжин” жүжигт Хасар барсыг нударгадан алах үйл явдал гардаг. Жүжгийн зургадугаар үзэгдэлд “... нэгэн аймшигтай барс үсрэн гарч ирмүй. Хасар яаран зайлж шидмээр занчин ормуй, хоёулаа нэг зэрэг занчилдаад Хасар төдий шидмээ хаяж нударга далайн орж барс лугаа барилцан ноцолдон байтал ... Хасар барс унасныг үзээд дахин дахин нударгалж ...” (Мандуга & Цэдэв, 2008, х.652) хэмээх сонирхолтой дүрслэл буй.

Баатар эр барс алах мөртөө нударгаараа алах үлгэрийн мотив хятадын “Хүйтэн уулын бичиг”-т ихээхэн тусгалаа олсон байдаг. Хасарын барс алсан тухай дүрслэл нь “Хүйтэн уулын бичиг”-тэй холбон бодоход хүрч буй. “Хүйтэн уулын бичиг”-т У Сүнгийн барс алсан үлгэрийг дүрслэхдээ “У Сүн барс шүүрэн ирэхийг үзэж хоёр гараар шидэмийг өргөн агуу хүчээ гарган занчив... Модны салаан дээр занчсан аж. Шидэм дундуур хугараад нэгэн хагас нь гарт үлджээ. Тэр барс орхирон догширч бие урван дахин дахин үсрэн ирэв... У Сүн хугархай шидэмээ орхин хоёр гараар барсын толгойноос овоодож дорогш хүчлэн дарав.

Зүүн гараар барсын толгойн арьснаас нь чадлын чинээгээр чанга атгаж баруун гараа суллан авч төмөр манжарга мэт нударгаар барсын толгой уруу хүчлэн занчсаар жар дал удаа нударгадсан...” (Шүй Хэүгийн үлгэр, 1978, х.518) гэжээ. “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжиг дэх Хасарын барс алсан үлгэрийн хэвтэй адилтган үзвэл баатар эр юуны өмнө шидэм барин барстай тэмцэлддэг бөгөөд дараа нь шидэмээ орхин нударгаар тэмцэлдэх эцэстээ нударгадаж алах зэрэг талаараа У Сүнгийн барс алсан үлгэртэй ижил юм. Ялгаатай тал нь гэвэл, “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжигт Хасар барсыг нударгадаж алсан гэдэг боловч барсын үхсэн нь Билгүүдэйн суманд оногдсонтой холбогдох, Хасарын шидэм У Сүнгийн шиг хугарсангүй, харин тусгай шидэмээ орхин нударгаар тэмцэлдэн орсон зэрэг талын дүрслэл нь ондоо байна. Барс алсан үлгэртэй ижил байвал “Хүйтэн уулын бичиг”-тэй холбогдох ёстой биш. Гэхдээ уг жүжгийн зарим нэг агуулгууд нь “Хүйтэн уулын бичиг”-тэй ямар нэгэн хэмжээгээр холбоотой болохыг дараах агуулгаар баталсан бөгөөд урьдчилж энэхүү барс алсан үлгэрийг тохиолдлоор холбон тайлбарлах аргагүй юм.

### **Хоёр. Баатруудын дүрийн онцлог.**

1. **Хасарын дүрийн онцлог:** “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжиг дэх Хасарын дүрийн илэрсэн зан чанарыг ажиглахад чадал хүчтэй, эрэлхэг зоригтой, уур омог ихтэй бөгөөд цөлс цайвар, амархан баярладаг, гүн нарийн бодолгүй зэрэг онцлогтой.

2. Энэхүү зан чанарт илэрсэн гадаад дүр төрхийг “ихэд баярлан, ихэд инээн, ихэд уурлаж, ихэд уйлан, ихэд хилэгнэн” хэмээн дүрсэлсэн зүйл олон харагдана. Тус жүжгийн нэгдүгээр үзэгдэл болох “Есүхэйн мордсон нь” хэмээх бүлэгт Есүхэй баатар Өүлэн эх хоёр хүүхдүүдээ эрдэм боловсрол хийлгэж, хүч чадлыг нь шалгаж үзэх үйл ажиллагаа явагдана. “Монголын нууц товчоо”-нд огт холбогдохгүй энэхүү агуулгыг оруулан нэмж зохиосон нь жүжиг найруулгын хувьд сонин биш юм. Харин сонирхолтой хэсэг нь эрдэм боловсрол хийлгэж тус агуулгыг бүх утгаараа Хасарын дүрийн зан чанарыг илэрхийлэхийг зорьж буй аж. Есүхэй баатар Билгүүдэйг сайн харваач болно гэж магтахад Хасар атаархан өөрийгөө сайн харваж буй гэж худал хэлэх, Билгүүдэйтэй



нум сум харван мөрийцөхийг шаардахад Хасар харин “манжаргаа шүүрэн авч нэгэн этгээдэд зогсож” (Мандуга & Цэдэв, 2008, х.635) зодохыг бэлтгэх, Билгүүдэйн оносон сумыг өөрийнхөө хэмээн булаалдах, харвах эрдмээр Билгүүдэйг ялахгүй хир нь зэвсгийн эрдмээрээ үзэлцэнэ гэж Билгүүдэйг хайхралгүй чавчин орох бусдын хориглохыг үл сонсох ... зэрэг Хасарын зан чанараас олон чанарыг товойлгон дүрсэлж бараг бүх талаар Хасарын дүрийг шуун бүтээжээ.

Тайчууд Чирлах өвгөнийг хатгаж орхиод явахад “Хасар их л хилэгнэн тэр явсан зүгт зааж хараан хэлрүүн, урвасан хулгай нар бүү яар. Би нэгд нэггүй манжаргадан арилгасугай” (Мандуга & Цэдэв, 2008, х.646) гэсэн ба “Би очъё. Та нар боль, тэд нараас юун айх вэ” (Мандуга & Цэдэв, 2008, х.647) гэхэд Өүлэн эх Хасарыг хориглон зогсоох, Чирлах өвгөнийг үхсэн учрыг Хасар сая мэдэж, урагш нэгэн зэрэг татаж чангаагаад эх, ах нарын уйлахыг үзээд гэнэт их дуугаар хүрхэртэл хашгиран сая мэдсэн мэт уйлах” тайчуудтай байлдсан дайнд Хасар “муу хулгай нар үхэхээс үл айх аваас нэг нэгээр гарч ирэгтүн, хоёр хоёроор ирэвч мөн болмуй” (Мандуга & Цэдэв, 2008, х.652) хэмээн хорсон хараасан ба тайчуудын цэргийг хэт зөрсөнгүй занчин унагааж байх, “нэг тайчууд байтугай хэсэг тайчууд ирэвч юунаас айх вэ? хэмээгээд “ижий биднийг явж тоглогтун” хэмээж буй хэмээн Тэмүжин Билгүүдэй нарыг чирсээр ормуй” (Мандуга & Цэдэв, 2008, х.651) гэх зэрэг жүжгийн бүх агуулгын хувьд Хасар нь хамгийн эрэлхэг зоригтой, хүч чадалтай, уур хилэн ихтэй, цөлс бүдүүлэг хүний хувиар шуун бүтээжээ.

Ийнхүү Хасар монгол уран зохиолын дүрүүдэд урьд байгаагүй сонирхолтой дүрээр дүрслэгджээ. Хасар нь атаа жөтөө ихтэй, чадал хүчтэй, эрэлхэг зоригтой, уур омог ихтэй бөгөөд цөлс цайвар, амархан баярладаг, амархан уурладаг, гүн нарийн бодолгүй зэрэг зан чанарын онцлогтой. Тэрчлэн бас манжарга атган байлдах байдал, барс алах, барсыг нударгадаж алах нь бидэнд “Хүйтэн уулын бичиг” дэх барс алсан У Сүн хийгээд нөгөө Ли Күй, Лу Хи Шень зэрэг баатар эрийн зан чанарыг холбон сэтгүүлэхэд хүргэж байна.

3. **Тэмүжиний дүрийн онцлог:** “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжигт илрэх бас нэгэн хачирхалтай зүйл гэвэл бүх жүжигт

Тэмүжиний дүр ер нь аймхай, шуурхай бус байдаг. Хамаатай агуулгыг жишээгээр үзүүлбэл:

Тэмүжин тайчуудаас дутаан явж байгаа үес “Тэмүжин ихэд цочин ийш тийш айсан мэт харж ийн хэлрүүн, ай хэрхэх билээ би одоо энэ уулаас яахин гарах билээ хэмээн тэндээ мориноосоо бууж бага суумуй.... Тэмүжин толгойгоо сажлан гаслан хэлрүүн юутай зовлонтой, юутай аймшигтай буй, тайчууд намайг эрхбиш барьсугай хэмээмүй хэмээгээд дахин буцаж алхлан толгойгоо унжуулсаар ....” (Мандуга & Цэдэв, 2008, х.654) гэж, Тэмүжин тайчуудад баригдаад байсан үеийн байдлыг дүрслэхдээ “Тэмүжин тэднээс нэгэн цэрэгт сахигдаад толгойгоо унжуулжүхэхээ хүлээн уйлан сууж байн байн санаа алдан, эжий эжий, дүү минь дүү минь ....” (Мандуга & Цэдэв, 2008, х.658) хэмээн гашуудан уйлж байснаас биш зоригтойгоор арга ухаан сүвэгчилж байгаагүй юм.

Чирлаа өвгөний нас барсан үеийн гашуудлын байдлыг бичих үед Хасар: “урвасан хулгай нар бүү яар, би нэгэд нэггүй манжаргадан арилгасугай хэмээгээд за та нар бүү уйл” (Мандуга & Цэдэв, 2008, х.646) гэсэн байхад, Тэмүжин их л дуу тавин уйлж “тодтойёо биднийг орхиж урван явахдаа өвгөн эцгийг жадлан одсон баймуй. Үнэхээр муу санаатай хэмээн уйлмуй” (Мандуга & Цэдэв, 2008, х.646) гэх. Тайчуудаас дутаан уснаас гараад “өвгөний дэргэд ирж сөгдөөд их л уйлан хэлрүүн өвгөн аав өршөөж амийг авармуй. Би ах дүү нарын хамтаар гөрөөлөн явж тайчууд аймагт баригдаад тун саяхан дутаан гарч энд нуугдан буй” (Мандуга & Цэдэв, 2008, х.661) гэх. Сорхон шарын гэрт хүрээд “Тэмүжин уйлан сөгдөж хэлрүүн, өвгөн эцэг өршөөн нигүүлсэж өчүүхэн амийг тэнхрүүлэн соёрх. Миний бие гурав дөрвөн өдөр юм олж идсэнгүй, тэсэхүйд бэрх болов” (Мандуга & Цэдэв, 2008, х.662) гэх. Тэмүжиний тухай ийм мэтийн дүрслэл их харагдаж байдаг. Жүжгийн нэгдүгээр үзэгдэлд, Есүхэй баатар Тэмүжинийг дагуулан олхонууд иргэнээс бэр гуйхаар явахад Хасар “аавд дайсан уулзвас хэрхэх вэ? аав болбоос настай болсон. Ах болбоос тэнхээгүйн дээр аймтгай, би явалцвас сая санаа амар мэт” (Мандуга & Цэдэв, 2008, х.640) гэжээ. Энд Хасарын амаар Тэмүжинийг тэнхээгүй бөгөөд аймтгай хэмээн тушаасан нь мөнхүү сонирхолтой.

Жүжигт гарах Тэмүжиний тухай бүх дүрслэлийг бүртгэн үзэхэд аймхай, уйланхай, огт эсэргүүцлийн зориггүй, эрдэм чадалгүй бөгөөд арга ухаан ч үгүй нэгэн дүр болсон аж. Тайчуудын цэргээс дутааж гарч ирсэн байдлыг бичихдээ ч эв энгийн байдалтайгаар дүрсэлж ер нь хэн байсан ч тэгж дутааж гарч чадах тиймэрхүү маягаар бичжээ. Жүжигт гарч буй олон удаагийн дайн тулалдаанд Тэмүжиний дүр бараг айх, уйлах, дутаах зэргээс ондоо дүрслэлээр харагдаагүй байна. Тэгвэл уг жүжиг дэх Тэмүжиний дүр нь яагаад ингэж бүтээгдсэн бэ? Уг жүжгийг “Хүйтэн уулын бичиг”-тэй ер нь нэгэн зүйлийн сонирхолтой харьцаа бий хэмээх үзэлтийн дагуу гүнзгийрүүлэн үзвэл, жүжиг дэх Тэмүжиний дүр нь “Хүйтэн уулын бичиг” дэх Сүн Жангийн дүрээс нөлөөлөгдөн зохиогдсон боломж байх болов уу хэмээн сэтгүүлэхэд хүргэж байна. “Шүй Хугийн үлгэр” дэх Сүн Жангийн дүр бол гуйвамтгай, назгай, эрэлхэг зоригоор дутмаг, аймхай зэрэг зан чанарын онцлогтой байдгийг тайлбарлан нуршихыг энд товчилъё. Ийнхүү “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжигт нэлээд хүний нэр гардаг боловч Хасар Тэмүжин хоёроос бусад олон дүр зураглалгүй. Монгол уран зохиолын түүхэнд хүч чадалтай, цөлс цайлган баатрын дүр цөөнгүй шуугдан бүтээгдсэн боловч “Баатар хөвгүүн Тэмүжин” дэх Хасар шиг тэнэг бүдүүлэг, ихэд баярлан, ихэд инээн, ихэд уурлаж, ихэд уйлан, ихэд хилэгнэн, хараан доромжлох тийм маягийн баатрын дүрслэлийг олж харахгүй аж. Хасарын дүр бүтээлгэ жич түүндээ зохицсон хэллэг, дүрслэлүүд нь “Хүйтэн уулын бичиг” дэх Ли Куй, Лу Хи Шень, У Сүн нарын дүрийг бүтээсэн арга загвартай нийцэж, барс алсан үлгэртэйгээ ч ам сээр золгож болох талтай.

Нөгөө талаар өгүүлэн буй тус жүжиг нь “Баатар хөвгүүн Тэмүжин” хэмээх нэртэй атлаа Тэмүжин нь огт баатар биш байдаг нь “Шүй Хугийн үлгэр”-тэй нэн ч дотоод холбоотой болов уу хэмээн бодуулахад хүргэж байна. Хасарыг барс алуулж бас У Сүн, Ли Куй нарын дүр загварт оруулан шуун бүтээсэн бол харьцуулан буй хоёр уран бүтээл дэх түүрүү (буюу хаан) нарыг хооронд нь адилхан хэвд шуун бүтээх тийм боломж яриангүй байж болох юм. Уг жүжиг дэх Тэмүжиний аймхай, уйланхай, эрдэмгүй, зориг цөсгүй байдаг тийм маягийн дүрийг бүтээсэн нь Тэмүжинийг “Хүйтэн

уулын бичиг” дэх Сүн Жангийн дүрд тохон оруулж шуун бүтээсэнтэй холбоотой байж болох юм. Монгол уран зохиолын түүхэнд Тэмүжин Чингис хааны дүрийг иймэрхүү аймхай маягаар шуун бүтээсэн бүтээл өөргүй мэт байна. Ийнхүү уг жүжиг дэх Тэмүжиний дүр бол монгол уран зохиолын түүхэнд бүтээгдсэн нэгэн онцгой үзэгдэл болох аж. Онцгой дүртэй болсон шалтгаан бол энэхүү жүжиг нь “Шүй Хэугийн үлгэр”-ийн арга загварыг мөрдөн бичигдсэнтэй холбоотой юм.

### **Гурав. Үйл хөдөлгөөн хэл хэллэгийн харьцуулал**

“Баатар хөвгүүн Тэмүжин” жүжиг дэх Хасарын барс алсан үлгэр жич зарим сонирхолтой дүрүүдийн харьцуулал дээр тус жүжиг нь “Хүйтэн уулын бичиг”-тэй ямар нэгэн хэмжээнд холбогдохыг өмнө хоёр хэсэгт өгүүлсэн билээ. Энэ хэсэгт тус жүжгийг “Хүйтэн уулын бичиг”-тэй хэрхэн холбогдох жүжгийн хэл хэллэг, үйл хөдөлгөөний дүрслэл зэрэг талаар энд өгүүлэх болно. “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжгийн зургадугаар үзэгдэлд Хасар тайчуудтай байлдсан байлдааны тухай дүрслэхдээ “Тайчуудын баатар хэлрүүн, та нар өчүүхэн нялхсууд бидний гараас гарахуйд бэрх, энэ өдөр нэгд нэгэнгүй баримуй... Хасар тэр үгийг сонсоод их л хилэгнэн муу хулгай нар үхэхээс үл айх аваас нэг нэгээр гарч ирэгтүн, хоёр хоёроор ирэвч мөн болмуй .... тайчуудын бүлгээс нэгэн баатар угтан ирмүй, Хасар түүн лүгээ хэд зөрсөнгүй занчин унагаагаад дахин дуудмуй бас нэг баатар ирээд дийлэлгүй дутаамуй” (Мандуга&Цэдэв, 2008, х.653) гэжээ. Хоёр талаас тус бүр нэгэн жанжин гарч ирэн зэвсэг зөрөлдүүлэн угтан байлдах, зөрсөн зэвсэгийн тоог тушаах бол хятад бүлэгт роман (буюу хуурын үлгэр)-уудын дайн байлдааны дүрслэлийн чухал нэгэн хэвшил юм. Иймэрхүү маягийн дайны дүрслэл нь “Хүйтэн уулын бичиг”-т олон дахин илрэх нь мэдээж. “Хүйтэн уулын бичиг”-т “хоёр жанжин морь довтолгон талбарт гарч, атган зэвсгээ өргөж зөрөлдөн байлдаж үүсгэснээ Со Чао уур түрэн саран сүхээ далайж Ян Хигийн зүг байлдан орсноо, Ян Хи алах уур мандуулан хувилгаан жадаа эргүүлэн Со Чаог угтан авав.

Хүр хүрсээр хүрэвч, гүрвэн даран орж, ар өврөөр нийлж, атган зэвсэг харшилдуулж,



хойгуур урдуур нийлж хүлэг морь зөрөлдүүлж дөч тавин удаа болтол дийлэн дийлэгдэх ялгарсангүй” (Шүй Хэүгийн үлгэр, 1978, х.292) гэжээ. Энэ жишээнд мөн хоёр талаас тус бүр хоёр жанжин гарч ирэх, зэвсэг зөрөлдүүлэн байлдах, хэдий удаа зэвсэг зөрөх зэргийг тушаажээ. Иймэрхүү маягийн жишээ “Шүй Хэүгийн үлгэр”-т цөөнгүй бий. Өгүүлэн буй жүжигт, хоёр этгээдээрээ байлдаанаас өмнө харилцан хорсолын үг ярих (онцгойлон “муу хулгай” хэмээн хэлэх), нэр алдраа асуух нь хятадын бүлэгт роман, бенсэн үлгэр буюу хуурын үлгэрт үргэлж гардаг агуулгууд юм. Тус жүжигт эсрэг этгээддээ “муу хулгай” хэмээн хорсолын үг хэлэх ба “түүн лүгээ эрэгчин, эмэгчинээ ялгасугай” (Мандуга & Цэдэв, 2008, х.647) гэх зэрэг нь ч “Шүй Хэүгийн үлгэр” (буюу хятадын бүлэгт романууд)-тэй адилхан байна.

“Баатар хөвгүүн Тэмүжин” жүжгийн хэллэгийг шүүн үзвэл уламжлалт монгол уран зохиолд байж боломгүй харин хятадын эртний бүлэгт романуудад байдаг хэл хэллэг, зан байдлын дүрслэл цөөнгүй харагдаж байна. Жүжгийн эхний хэсэгт, Есүхэй баатар Тэмүжинийг дагуулан Өүлэн эхийн төрхмөөс бэр гуйхаар явах замдаа Дашжинтай уулзан охиныг нь бэр болгон гуйж тохирсон үлгэрийг өгүүлэхдээ “эрсэн хүссэн явдал харин танай гэрээс бүтэх мэт... ай миний хүүхнийг голохгүй аваас эрхэмийн агьд гэргий болгохоос үл татгалзмой. Тэмүжин Бөртэгэлжин хоёул ичингүйрч нүүрийг даруй (даран - эшлэгчээс) баймой” (Мандуга & Цэдэв, 2008, х.642) гэх Есүхэй баатар ба Дашжин нарын хэлсэн үг жич Тэмүжин ба Бөртэгэлжиний тухай дүрслэл байдаг. Энэхүү агуулгад хятадын уламжлалт зохиолд харагдах хэллэг жич хятадын феодалын нийгмийн онцлог шинж ихээхэн байна. Харин “товчоо”-ны уг бичлэгтэй ихээхэн гажиж, монголын уламжлалын уран зохиолд огт харагдахгүй сонин хэллэг гарч байдаг. “Миний хүүхнийг голохгүй аваас”, “агьд гэргий болгох”, “ичингүйрэх” зэрэг хэллэг нь хятад роман дахь сурвалжлалт өрхийн ураг садан бололцоход гардаг хэллэг ба заншилтай адил тал байгаа бөгөөд “агь” гэх мэтийн үгийг хэрэглэж буй нь зохиогч бээр Чин улсын үеийн монгол орчуулгын зохиолуудыг цөөнгүй уншиж байсны жишээ юм. Есүхэй баатар Дашжингийн хамт гэрт нь охиныг нь үзэхээр ирсэн

үзэгдлийг дүрслэхдээ “Дашжин эхнэртээ хандан, та нар танилцан ёслогтун” хэмээв. Эхнэр хүүхэн нь төдий мэхийсхийн ёсолж амгалан айлтгахуйд Есүхэй баярласандаа босон харайн хариу ёслоод тэр хүүхнийг ихэд ажиглан байвай” (Мандуга & Цэдэв, 2008, х.642) гэсэн бөгөөд “Юутай сайхан гэргий юутай сайхан охинтой буй миний эрсэн хүссэн явдал харин танай гэрээс бүтэх мэт” (Мандуга & Цэдэв, 2008, х.642) хэмээн тухайн талбарын үйл хөдөлгөөнийг дүрсэлжээ. Эхнэр хүүхэн нь “мэхийн ёслох”, Есүхэй баатар “босон харайн хариу ёслох” жич эхнэр хүүхнийг нь “юутай сайхан” хэмээн магтах зэрэг нь бүр ч хятадын бүлэгт романы хэллэг, дүрслэлтэй зохицож буй. Есүхэй баатар Дашжинтай хүүхдийн ургийн учрыг хэлэлцэн бүтсэний дараа Есүхэй баатар уг учрыг “эмгэндээ хэлбээс” сая санаа амрах гэдгээ хоёр удаа дурджээ. Даруй “Одоо миний хэрэг бүтсэн тул одоо энэ цагаар буцаж эмгэндээ хэлэхээр одсугай гагцхүү гуйх нь миний бэрийг манайд нэг хэд хоногоор очуулахыг хүсэх бөгөөд дараагаар хурим бэлэгийг гүйцэтгэх ёслол буулган авчсугай” (Мандуга & Цэдэв, 2008, х.642), “Би юм сонсвоос хэлэлгүй амрахгүй нэг юм үзвээс өчилгүй тогтохгүй ийм зантай хүн бүлгээ одоо энэ өдрөө эртхэн харьж эмгэндээ хэлбээс сая санаа амрах баймой хэмээн төдий явахаар тогтож хөвгүүн юүгээ тэврэн үнсэж хэдэн үг захиад гарч одмой” (Мандуга & Цэдэв, 2008, х.642) гэжээ. Энд Есүхэй баатар нэг их ихэмсэг байгаагүй мөртөө хятадын бүлэгт роман дахь “шударга иргэн”-ий дүрээр илэрсэн мэт. Уламжлалт монгол уран зохиолоос эрс ялгагдах дүрслэл хэллэгүүд ингэж харагдаж байгаа билээ.

Тэмүжин Сорхон шарын тусламжаар аврагдсаны дараа “та болбоос ертөнцөд хосгүй өршөөл журамт хүн бөгөөд таны энэ их ачийг хэрхэн умартаж болох аж. Хэрхэвч хариулахыг хүсмүй. Чухам нь дахин төрүүлсэн эцэг, эх болой хэмээн нэг зэрэг хэлэлцээд...” (Мандуга & Цэдэв, 2008, х.663) салан оджээ. “Өршөөл журамт хүн” хэмээгч үг бол хятадын бүлэгт романд олон дахин хэлэгддэг тусгай хэллэг юм. өршөөл журамтай байх бол хятадын феодалын цаг үеийн дээд давхаргын дунд яригддаг хамгийн эрхэм чанар, сайн хүний чухал баримжаа билээ. “Ертөнцөд хосгүй” хэмээх үг ч хятадын бүлэгт романд олон дахин яригддаг юм. ямар нэгэн онцгой зүйлийг

дэлхий ертөнцтэй холбон өгүүлэх жич өөрийн улс орноо ертөнц дэлхий гэж хэлдэг нь тэдний ертөнцийн үзэл, өртөгийн үзэлтэй холбоотой байж болох юм. “Онц сайн, маш, тун” гэх утгаар хэрэглэх нь олон, “Ачийг умартах”, гэх үгийг ч хятадын бүлэгт романд олон дахин хэрэглэдэг аж. Энэ нь ачлал элбэрэлийг журамлах хэмээх хятадын эртний бичгийн сургаалтай холбогдох тусгай нэрийдлийн үг болох юм. Монгол уламжлалт зохиолуудад огт харагдахгүй эдгээр тусгай нэрсийг уг жүжигт хэрэглэж байгааг бид тохиолдол хэмээн тайлбарлахын аргагүй аж. Ийнхүү “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжгээс уламжлалт монгол уран зохиолын хэл хэллэг ба үйл хөдөлгөөний дүрслэлүүдийг үндсэндээ олж харахгүй бөгөөд нарийвчлан үзвэл хятадын бүлэгт романы бичлэгийн арга, хэл хэллэгийн зүйл цөөнгүй харагдаж байгааг дээр хэдэн жишээнд тулгуурлан өгүүлсэн билээ. Эдгээр онцлогууд нь өгүүлэн бүхий “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжиг “Хүйтэн уулын бичиг”-ийн нөлөөг хүртсэн зэрэг нотолгоо нь чухал баримт болж байна.

### **Дөрөв. Зохиогч бээр “Хүйтэн уулын бичиг”-тэй танилцах боломжууд**

Монгол улсын орчин үеийн их онолч Сономбалжирын Буяннэмэх бээр хятадын бүлэгт роман “Шүй Хэү шаштир”-тай танилцах боломж байсан эсэхийг хайх нь “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжгийн “Хүйтэн уулын бичиг”-тэй ямар байдлаар холбоотой тухай асуудлын гол зангилаа болох аж.

1. Тогтох тайжийнд байхдаа “Хүйтэн уулын бичиг”-тэй танилцах боломж С.Буяннэмэх 9 насандаа (1911 онд) түүний хүргэн ах болох цахар Лувсангийнхаас Өвөрмонголын Тогтох тайжийнд “үрчлэгдсэн” буюу “шавь болсон” гэх эрдэмтдийн адил бус баримт, санал байдаг юм. Тогтох тайжийнд “үрчлэгдсэн” буюу “шавь болсон” гэх санал нь зөрөөтэй байгаа боловч Тогтох тайжийнд бага насандаа олон жил сууж байв гэдэгт эрдэмтдийн санал нэгдэж байгаа билээ. Олон эрдэмтэд энэ мэт тэмдэглэж ирснийг үндэслэн С.Буяннэмэх бээр Тогтох тайжийн гэрт байсан гэдгийг үнэмшиж болох талтай боловч Горлос нутагт Тогтох тайжийн гэрт байсан гэж төсөөлөх нь үнэмшилгүй байна. Учир нь Тогтох тайжийн Горлос нутагт аж төрж байсан цаг хугацаагаар тулгаж үзвэл иймэрхүү боломж харахан

үгүй харин Тогтох тайж бээр монголд нүүж очсоны дараа тэдний гэрт С.Буяннэмэх нэг үе сууж байсан гэж хэмээн үзэх нь зүйтэй билээ. “Тогтох тайжийн гэрийн багшаас монгол, манж, хятад бичиг сурч байсан” (Мандуга, 2004, х.58) гэдэг нь ч олон ном бичиг буюу сурвалжлагын баримтуудад нэгдэлтэй байна. Тэгэхдээ хэн гэгч багшаас сурч байсан бэ гэдэг тухай эрдэмтдийн санал бүрэн нэгдэж чадаагүй юм. Профессор Ван Мандуга, профессор Эрхэмбаяр (сурвалжлагын материал)-ын С.Буяннэмэх судлалын тухай ном зохиолуудаа Монгол ард улсын Шинжлэх ухааны академийн Хэл утга зохиол судлах газрын найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” тэргүүн боть (1921-1940) зэрэг номд “Ашинга зэрэг хүн” буюу “Харчин угсааны Ашинга гэдэг хүн” -ээр (Буяндэгжрэх, 1984, х.120) бичиг заалгаж байсан гэж байхад, Буяндэгжрэхийн “Монгол ард улсын утга зохиолын тойм” номд “Эрдэнэ зэрэг хүмүүсээр бичиг заалгаж байсан” (Буяндэгжрэх, 1984, х.120) гэжээ. Хэнээр бичиг заалгаж байсан нь хамаагүй, харин С.Буяннэмэх бээр 9 наснаасаа хойш 7 жил Тогтох тайжийн гэрт байсан бөгөөд гэрийн багшаар бичиг заалгаж байсан гэдэг нь дээрх мэт баримтаар батлагдаж байгаа билээ.

Профессор Эрхэмбаярын докторын эрдмийн цол горилсон өгүүлэлд “Тогтох тайж орой болгон үлгэрч туульч нарыг цуглуулан явган үлгэр яриулан, хуур хөгжмийн эгшиг үүсгэн, тууль хайлдаг байсан нь бага насны Буяннэмэхийн хүмүүжил боловсролд маш их нөлөө үзүүлжээ” (Эрхэмбаяр, х.17) гэсэн байдаг. Энэхүү “үлгэр яриулан, тууль хайлдаг” байсан нь сонирхолтой байна. Энд өгүүлэн бүхий Тогтох тайж бол Жирэмийн чуулганы Горлос нутгийн Тогтох баатрыг зааж буй. Тухайн үед Өвөрмонголын зүүн хэсгийн Зост, Жирэм зэрэг газар орны монголчуудын дунд бенсэн үлгэр их хэмжээгээр орчуулагдаж байсны зэрэгцээ бенсэн үлгэрийг хуур хөгжмийн хавсарлагатайгаар “хуурын үлгэр” болгон ярьж байсан аж. “Тан улсын таван Юань”, “Шүй Хэүгийн үлгэр” “Тансан ламын үлгэр”, “Турван улсын үлгэр” нь их хэмжээгээр орчуулагдан өвөр монголын зүүн орны ардын дунд өргөн хэвчээгээр тархан уламжлагдаж байсан юм. Тогтох тайж орой болгон “үлгэрч туульч нарыг цуглуулан явган үлгэр яриулан хуур хөгжмийн эгшиг үүсгэн тууль хайлдаг”



байсан нь чухам юу ярьж байсан бэ?, зохиогч С.Буяннэмэх “Хүйтэн уулын бичиг”-ийн үлгэрийг хуурын үлгэр сонсох, бенсэн үлгэр дуудах эсхүл явган үлгэрээр зэрэг олон талын боломжоор хүлээн авсан байж болох юм.

2. Монгол орчуулгаар дамжин “Хүйтэн уулын бичиг”-гэй танилцах боломж

“Шүй Хэүгийн үлгэр” эрт үед халх монголд “Сүн улсын хүйтэн уулын бичиг” буюу “Шүй Ху Жиувангийн бичиг” хэмээх хоёр зүйлийн орчуулга байсан. Өмнөх орчуулгынх нь ар хуудсанд “Их Дайчин улсын хэвт ёсны тэргүүн он, зуны дунд сарын арван гуравны сайн өдөр бичиж төгсгөв. Бичээч лам Бат нягт билигт түшмэл зайсан Чагдаржав хурц билигт нар сийрүүлэн бичвэй. Тавдугаар жинсэ Сяньшен Вен Шен У хэмээх өлзийт түшмэл зайсан Банданцэрэн билигт, Цогтбадрах хичээнгүй нар монголчлон орчуулбай” (Дамдинсүрэн & Жамсранжав, 1991, х.481) гэжээ. Энэ нь тус бичгийг 1909 онд орчуулсан ба хэн гэгч хүн орчуулсан гэдгийг мэдээлжээ. Хойно нь орчуулагдсан цагийн тухай тодорхой мэдээ байгаагүй “Шүй Хугийн үлгэр”-ийн орчуулгыг монголд бас “Мөрний хариг”, “Усан бялхмал” гэж адил бус нэрээр нэрлэдэг юм. Онолч Сономбалжирын Буяннэмэх бол 1902 оноос 1937 оны хооронд аж төрж байсан хүн билээ. 1909 онд монголд орчуулагдан дэлгэрсэн энэхүү “Шүй Ху шаштир”-ыг тухайн үеийн их бичгийн хүн асан С.Буяннэмэх мэдэхгүй өнгөрөх боломжгүй юм.

### ДҮГНЭЛТ

Ийнхүү онолч Сономбалжирын Буяннэмэхийн намтар түүх ба амьдарч байсан тухайн цаг үе, өвөр монголтой онцгой харьцаатай байсан жич дээр өгүүлсэн баримтууд нь “Хүйтэн уулын бичиг”-ийг танин мэдэх тэрчлэн сайн ойлгох боломжтой байсан гэдгийг харуулсан билээ. Зохиогч би бээр хэдэн жилийн өмнө “С.Буяннэмэхийн зохиол бүтээл дэх харь нөлөө” хэмээх нэгэн өгүүлэлдээ С.Буяннэмэх “Шүй Хэү шаштир”-ыг Тогтох тайжийнд байхдаа гэрийн багшаас хятад хэл сурах бичиг ч болгож байсан магад хэмээх зүйлчлэлийг хийж байсан билээ. Гэвч бид “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжгийг нарийвчлахад С.Буяннэмэх “Хүйтэн уулын бичиг”-ийг зүгээр үлгэр домгоор сонссон биш харин монгол орчуулгаар нь үзсэн боломж нэн их байна. Учир юунд гэвэл, “Баатар хөвгүүн Тэмүжин” жүжгийн хэл хэллэгийг хэрэглэж байгаа тал нь бичиг зохиолын хэвшилд нэлээд нөлөөлөгдсөн шинж ажиглагдана. Ерөнхийлбэл, их онолч,

монголын орчин үеийн уран зохиолын үндэслэгч Сономбалжирын Буяннэмэхийн “Баатар хөвгүүн Тэмүжин” хэмээх жүжгийн зохиолын үйл явдал, хэл хэллэг, урлагийн онцлог зэргийг хятадын бүлэгт роман “Шүй Хэүгийн үлгэр”-тай харьцуулан үзэхэд адил талууд цөөнгүй байгаа нь дээрх баримтуудаар батлагдаж байгаа билээ. Онолч С.Буяннэмэх өвөр монголын Тогтох тайжийн гэрт бага насаа өнгөрүүлсэн нь хятадын “Хүйтэн уулын бичиг”-ийг сайн ойлгож байсан боломж бий хэмээн зүйчилж болох талтай боловч ХХ зууны эхэнд монгол улсад орчуулагдан тархаж байсан “Шүй Хугийн үлгэр” буюу “Хүйтэн уулын бичиг”-тэй танилцсан суурин дээр тус жүжгийг зохиосон боломж нэн их байгаа юм. Ийнхүү монгол түмний суут онолч, их зохиолч Сономбалжирын Буяннэмэхээр монгол уран зохиолын өв уламжлал төдийгүй дорно дахины утга соёлын шилдэг өв уламжлалыг суралцан шингээж, өөрийн урлагийн бүтээлдээ уялдуулж өгсөн цөөн эрдэмтдийн нэгэн билээ.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Буяндэгжрэх. (1984). *Монгол ард улсын утга зохиолын тойм*. Өвөр монголын сурган хүмүүжлийн хороо.
- ВанМандуга,Цэдэв,Д. (2008). *Сономбалжирын Буяннэмэх*. Үндэстний хэвлэлийн хороо.
- Ван Мандуга. (2004). *С.Буяннэмэхийн хоёр жүжгийн гар бичмэл эх ба түүний судлал*, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.
- Дамдинсүрэн, Ц., & Жамсранжав, Г. (1991). *Монголын уран зохиолын тойм*. (арван есдүгээр зуун). Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
- Жагми. (2004). *Зуу-Уд монгол жүжиг урлаг жич судалгаа*. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. х.436.
- Хасчимэг. (2007). *Хорьдугаар зууны монгол уран зохиолын судлал*. Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.
- Монголын орчин үеийн уран зохиолын түүх (1921-1941)*. (Тэргүүн боть). (1990). Өвөр монголын сурган хүмүүжлийн хороо.
- Шүй Хэүгийн үлгэр*. (1978). Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
- Эрхэмбаяр. *Хорьдугаар зууны монголын уран зохиолын тавцан дахь нэгэн онц билигтэн (докторын цол хамгаалсан өгүүлэл)*, Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн номын сангийн хадгаламж.